

ӨГҮҮЛЭЛ

Монгол Улсын импортын гаалийн тарифын шинэчлэл

Нямдаагийн Отгонсайхан*

*ХҮИС-ийн профессор, эдийн засгийн ухааны доктор,
otgonsaikhan32@gmail.com*

Шагдарын Энхбаяр

*Зүүн Хойд Азийн Эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн
Судалгааны хэлтсийн ахлах судлаач, Эдийн засгийн ухааны доктор,
enkhee@erina.or.jp*

Хураангуй. Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс чөлөөт худалдааны бодлого баримталсаар ирсэн бөгөөд өнөөдөр импортын урсгал эрс нэмэгдэж, түүхий эдийн экспорт хөгжсөнөөр дотоодын үйлдвэрлэл уналтад орсон, уул уурхайн бүтээгдэхүүнээс хэт хамааралтай улс болжээ. Иймд гадаад худалдааны бодлогыг хэрэгжүүлэх арга хэрэгслүүдийг эргэн харах, тэдгээрийг хэрхэн оновчтой хэрэглэх, шинэчлэх зэрэг асуудлыг судлах зайлшгүй шаардлага бий болоод байна.

Энэхүү ажлын хүрээнд Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс өнөөг хүртэл импортын гаалийн тарифын бодлого зохицуулалтын шинэчлэл хэрхэн хийгдсэн талаар судалж, импортын гаалийн тарифыг шинэчилснээр Монгол Улсын эдийн засагт үзүүлэх зарим үр нөлөөг авч үзсэн.

Түлхүүр үгс: гадаад худалдааны бодлого; импортын гаалийн тарифын бодлого, зохицуулалт; нэн тааламжтай тариф; ДХБ-тай тохирсон тарифын дээд хэмжээ; тарифын шинжилгээ.

* Corresponding author



I. Монгол Улсын импортын гаалийн тарифын шинэчлэлийн бодлого

Монгол улс 1990-ээд оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих өөрчлөлт, шинэчлэлийн зорилтыг хэрэгжүүлж эхэлсэн нь тус улсын хөгжилд шинэ хуудас нээсэн билээ. Энэ үеэс гадаад худалдаан дахь төрийн монополь алдагдаж, худалдааны түнш орнууд болон экспорт, импортын барааны нэр төрлийн бүтцэд ихээхэн өөрчлөлтийг бий болгосон юм.

Монгол Улсын гадаад худалдааны өнөөгийн байдлаас харахад, импортын урсгал эрс нэмэгдэж, түүхий эдийн экспорт цэцэглэн хөгжсөнөөр дотоодын үйлдвэрлэгчдийг зах зээлээс шахан гаргаж, уул уурхайн бүтээгдэхүүнээс хэт хамааралтай улс болжээ. Иймд гадаад худалдааны бодлогыг хэрэгжүүлэх арга хэрэгслүүдийг эргэн харах, тэдгээрийг хэрхэн оновчтой хэрэглэх, шинэчлэх зэрэг асуудлыг судлах зайлшгүй шаардлага бий болоод байна.

Бид энэ хэсэгт гадаад худалдааны бодлогын гол арга хэрэгсэл болох импортын гаалийн тарифын бодлого зохицуулалтын шинэчлэл Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс хэрхэн өрнөсөн талаар авч үзлээ.

Монгол Улсад бий болсон онцлог үйл явдлыг харгалзан импортын гаалийн тарифын зохицуулалтыг дараах үе шатуудад¹ хувааж болох юм.

Үүнд:

1. Шилжилтийн үе (1991 -1996 он)
2. Олон талт зохицуулалтын үе (1997 -2007 он)
3. Гаалийн тарифын зохицуулах үүргийг нэмэгдүүлсэн үе (2008-2014 он)
4. Үндэсний үйлдвэрлэлийг гаалийн тарифын бодлогоор дэмжсэн үе (2015 оноос хойш)

Шилжилтийн үе (1991 -1996 он).

ЗХУ болон Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл (ЭЗХТЗ) задарснаар Монгол Улсын хувьд дэлхийн эдийн засагт эзлэх байр сууриа үндсээр нь өөрчлөх зайлшгүй шаардлага бий болсон. Үүний нэг гол өөрчлөлт нь гааль, тарифын бодлогыг шинээр тодорхойлох шаардлага байсан юм.

Монгол Улсын Засгийн газрын 1990 оны 10 дугаар сарын 19-ний 101 дүгээр тогтоолоор төрөөс гаалийн талаар явуулах бодлогыг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага болох улсын Гаалийн ерөнхий газрыг Засгийн газрын дэргэд байгуулсан.

Улсын бага хурал 1991 оны 1 дүгээр сарын 28-нд “Гаалийн тухай” Монгол Улсын хуулийг баталж, тус оны 3 сарын 1-нээс мөрдөж эхэлсэн. Улмаар 1991 оны 6 дугаар сарын 21-ний «Гаалийн татварын тухай» Монгол Улсын бага хурлын 45 дугаар тогтоолоор импортын барааны

1 Н. Отгонсайхан. Пополнение бюджета Монголии на основе тарифного регулирования внешней торговли, кандидатская диссертация. Байкальский государственный университет экономики и права, Россия. –с.83

гаалийн тарифыг 15 хувиар тогтоож, шаардлагатай тохиолдолд импортын зарим нэрийн барааг гаалийн татвараас чөлөөлөх эрхийг Засгийн газарт олгосон. Энэхүү тогтоолыг шилжилтийн эхэн үеийн гаалийн тарифын бодлогыг тодорхойлох үндсэн баримт² гэж судлаачид үзэж байгаа бөгөөд өнөөгийн Монгол Улсын гаалийн тарифын үндэсний зохицуулалт бий болох үндэс суурь тавигдсан.

Монгол Улс Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн тухай Олон улсын конвенцид 1991 оны 9 дүгээр сарын 17-нд нэгдэн орж, 1993 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн. Энэ нь гадаад худалдаанд идэвхитэй оролцох, үндэсний гаалийн тарифын тогтолцоог бүрдүүлэх, олон улсын худалдааны гэрээ, хэлэлцээр хийх, зарим нэр төрлийн барааг гаалийн татвараас чөлөөлөх анхны алхам болсон.

Ийнхүү 1993 оноос БТКУС-ийн ангилалын дагуу үндэсний гаалийн тарифын жагсаалтыг боловсруулсан нь тарифыг ялгавартай тогтоох, зарим барааны гаалийн тарифыг бууруулах боломжтой болсон. Тухайлбал, цахилгаан эрчим хүч, эмийн бүтээгдэхүүн - 0%; сургуулийн хүүхдийн дэвтэр, брезент, цагаан даавуу -5%; гутал, ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон арьс боловсруулах тоног төхөөрөмж, автобус, троллейбус – 7.5%; цагаан будаа, элсэн чихэр – 10% гэх зэргээр тогтоож үндэсний гаалийн тарифын бодлогыг хэрэгжүүлж байв.

Түүнчлэн Монгол Улс 1991 онд Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ)-г нэгдэн орох хүсэлт гаргасан нь гаалийн тарифын үндэсний зохицуулалтыг олон улсын дүрэмд нийцүүлэн боловсруулах шаардлага гарсан. Энэ хугацаанд тус хэлэлцээрийн гишүүн 9 оронтой (АНУ, ЕХ, Канад, Япон, Австрали, Швейцар, Мексик) тарифын хэлэлцээр хийж импортын гаалийн тарифын дээд хязгаар 20%, дотоодод үйлдвэрлэх боломжтой мод, модон бүтээгдэхүүн, хивс, нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн, савхи, савхин бүтээгдэхүүн зэрэг БТКУС-ийн 23 кодын барааны хувьд 30%, цагаан архи, ликёр, ром, жин зэрэг согтууруулах ундаанд 35-50%, хувилаагүй этилийн спирт 75%, боловсруулаагүй болон дүнсэн тамхинд 40%, янжуур 30% байхаар тохиролцсон.

Монгол Улсын үндэсний гаалийн тарифын бодлогыг олон улсын жишигт хүргэх зорилгоор “Гаалийн тарифын тухай” хуулийг 1996 оны 5 дугаар сарын 20-нд УИХ-аас баталж, мөн оны 7 дугаар сарын 1-нээс мөрдсөн.

Уг хуулиар гаалийн тарифыг тогтоох, түүнийг хэрэглэх аргыг тодорхой болгож үндэсний гаалийн тарифын тогтолцоог бүрдүүлж өгснөөрөө чухал ач холбогдолтой болсон. Гаалийн тарифыг Монгол Улсын Их Хурал батлах ба шаардлагатай бол Монгол Улсын Их Хурал эрх олгосноор Засгийн газар гаалийн тарифын хувь, хэмжээг өөрчилж болохоор тусгасан. Гаалийн тарифын хувь, хэмжээг тогтоох,

2 Ш.Цогтоо. Гаалийн эрхзүй. Сурах бичиг. – Улаанбаатар.: Хөх судар, 2003. – Х.206

бууруулах, нэмэгдүүлэх, гаалийн татвараас чөлөөлөхдөө тухайн барааны код, нэр төрлийг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн дагуу заана гэдгийг хуульчилсан.

Энэхүү хууль нь Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед гадаад худалдаанд олон улсын эрхзүйн хэм хэмжээг хэрэглэх боломж олгосон. Өөрөөр хэлбэл, гаалийн үнийг тогтоох, барааны ангилал, гарал үүслийг тодорхойлоход олон талт зохицуулалтыг нэвтрүүлэх шинэ нөхцөлийг бүрдүүлсэн гэж хэлж болно.

Олон талт зохицуулалтын үе (1997 -2007 он). Монгол Улс 1997 оны 1 дүгээр сарын 29-нд Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын 130 дахь (анхдагч) гишүүн болсон нь гаалийн тарифын бодлогыг ДХБ-ын олон талт зохицуулалтын хүрээнд өөрчлөн шинэчлэх үүрэг хүлээсэн.

Монгол Улс ДХБ-д элссэнээр бусад гишүүн орнуудаас гарал үүсэлтэй бараанд нэн тааламжтай гаалийн тарифын хувь хэмжээ мөрдөх шаардлагатай болсон.

1996 оны “Гаалийн тарифын тухай” хуулийн 4.3-т “Гаалийн тариф нь ердийн, нэн тааламжтай, хөнгөлөлттэй хувь, хэмжээнээс бүрдэнэ” гээд 4.4-т “Монгол Улсад үндэсний нэн тааламжтай нөхцөл олгодог улсын гарал үүсэлтэй бараанд гаалийн тарифын нэн тааламжтай хувь, хэмжээ хэрэглэж болно” гэж заасан нь энэ шаардлагыг хангаж байсан гэж хэлж болно.

“Гаалийн тарифын тухай” хуулийг худалдааны олон талт зохицуулалтын хэм хэмжээнд нийцүүлэх зорилгоор 1998, 1999, 2000, 2001, 2004, 2005 онуудад 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Түүнчлэн Монгол Улс ДХБ-д элсэхдээ импортын гаалийн тарифын дээд хувь хэмжээг тохиролцож, ДХБ-ын холбогдох хэлэлцээрээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд тарифыг уг хэмжээнээс өсгөхгүй байх үүрэг амлалт авсан. ДХБ-тай тохирсон тарифын дээд хэмжээний энгийн дундаж хувь нь нийт барааны хувьд 17.5% (аж үйлдвэрийн бараа 17.3%, ХАА-н бараа 18.8%) байгаа бөгөөд БТКУС-ийн ангилалын 6 орны түвшинд ангилагдсан нийт барааны 77.7 хувьд нь 15 болон түүнээс дээш хувийн гаалийн тариф ногдуулах үүрэг амлалт авчээ³.

Монгол Улсыг ДХБ-д элсэх үед импортын гаалийн тариф 15% байсан ба хүлээсэн үүрэг амлалтын дагуу зарим барааны гаалийн тарифыг үе шатаар бууруулах төдийгүй зарим барааны гаалийн тарифыг өсгөх ч боломж байлаа. Гэтэл ДХБ-ын гишүүн болсноос хойш хэдхэн сарын дараа импортын бүх төрлийн барааны гаалийн тарифын хувь хэмжээг Засгийн газрын шийдвэрээр “тэг” болгосон⁴. Энэ нь дотоодын үйлдвэрлэгчдэд хүнд цохилт болж ихэнх үйлдвэрүүд хаалгаа барихад хүргэсэн ба Монгол Улс хагас үйлдвэржсэн орноос хэрэглэгч, түүхий эдийн бааз улс болоход түлхэц болсон аж. Ганцхан жишээ хэлэхэд, 1980-

3 https://www.wto.org/english/res_e/booksp_e/tariff_profiles19_e.pdf

4 “Импортын барааны гаалийн албан татварын тухай” Улсын Их Хурлын 1997 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 24 дүгээр тогтоол

аад онд жилд гурван сая хос гутал үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангахаас гадна илүүг нь экспортолж байсан бол импортын барааны гаалийн тарифыг тэглэснээр өмнөд хөршийн бүтээгдэхүүнтэй өрсөлдөх чадамжгүй болж, дотоодын үйлдвэрүүд устжээ.

Энэ нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, 1996 оны “Гаалийн тарифын тухай” хуулиар гаалийн тарифыг Монгол Улсын Их Хурал батлахаар заасны дагуу 1999 оны 6 дугаар сарын 3-нд “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” 27 дугаар тогтоолын хавсралтаар гаалийн тарифын хувь, хэмжээг УИХ-аас баталсан. Уг тогтоолоор ихэнх барааны импортын гаалийн тарифыг 5 хувь болгосон. БТКУС-ийн 8 орны түвшинд ангилагдсан нийт 5639 барааны зөвхөн 1.3 хувь нь ялгаатай тарифтай (19 бараа 15%, 8 бараа 3%, 48 бараа 0%) байжээ.

Энэ нь ДХБ-тай тохирсон импортын гаалийн тарифын дээд хэмжээнээс бараг 4 дахин доогуур байсан. Уг тогтоолд 2007 оныг хүртэл дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

- ✓ 2000 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор импортын гаалийн тарифыг 7 хувь болгож мөрдсөн.
- ✓ 2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор импортын гаалийн тарифын 7 хувийг 5% болгож, 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн.
- ✓ 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 44 дүгээр тогтоолоор

Импортын гурилын (БТКУС-ийн 11.01, 11.02) улирлын ялгавартай тариф мөрдөх хугацаа болох “8 дугаар сарын 1” гэснийг “7 дугаар сарын 1” гэж өөрчлөн 2002 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс дагаж мөрдсөн.

“Гаалийн тарифын тухай” хуулийн 4.2-т “Монгол Улсын хилээр нэвтрүүлэх барааны гаалийн тарифыг Улсын Их Хурал батална” гэж заасан нь мөн хуулийн 4.3-т заасны дагуу “... ердийн, нэн тааламжтай” 2 төрлийн тарифын хувь, хэмжээг аль алиныг нь батлахаар ойлгогдож байна.

Гэсэн хэдий ч “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” 27 дугаар тогтоолоор баталсан тарифын хувь, хэмжээ нь ердийн эсхүл нэн тааламжтай тарифын аль нь болох талаар тодорхой заагаагүй нь энэ хуулийн гол дутагдал болж байсан.

ДХБ-ын гишүүн орнууд худалдааны бодлогоо тодорхой хугацаанд тогтмол хянуулах үүрэг хүлээдэг бөгөөд Монгол Улс энэ үүргийнхээ дагуу 2005 оны 3 сард анх удаа бодлогоо хянуулсан. Монгол Улсын худалдааны нээлттэй бодлого явуулснаар гарсан өөрчлөлтийн үр дүнг сайшаан, өөрчлөлт шинэчлэлтийг цаашид улам эрчимжүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогын ил тод байдлыг хангах, зарим бараанд олгож буй экспортын татварыг арилгах, импортын болон дотоодын үйлдвэрийн зарим бараанд ногдуулж буй ялгавартай онцгой албан татварыг тэгшитгэх гэх мэт олон асуудлыг тодотгон зөвлөмж өгсөн.

Монгол Улс ДХБ-д элсэн орсноос хойш 10 жилийн дотор худалдаа дөрөв дахин буюу 919.8 сая ам.доллараас 2007 он гэхэд 4119.3 сая ам.доллар болж өссөн. Худалдааны бүтэц болон чиглэлүүдэд огцом өөрчлөлт гарсан хэдий ч Монгол Улс ДХБ-ын гишүүн болсны ялангуяа импортын гаалийн тарифын бодлогын үр нөлөөг хэмжсэн дорвитой судалгаа алга байгаа юм.

Шилжилтийн болон олон талт зохицуулалтын үед гаалийн тарифын улсын төсвийн орлого бүрдүүлэх үүрэг өндөр байсан бол 2008 оноос гаалийн тарифыг дотоодын импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг урамшуулахад чиглэгдэж эхэлсэн гэж үзэж байна.

Гаалийн тарифын зохицуулах үүргийг нэмэгдүүлсэн үе (2008-2014 он). Энэ үе шатанд хоёр гол онцлог байсан. Үүнд:

1. Төрийн бодлогын баримт бичигт гаалийн тарифын зохицуулах үүргийг нэмэгдүүлэх замаар үндэсний эдийн засгийг хөгжүүлэх асуудлууд тусгалаа олсон.

Монгол Улс 2008 онд Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний Хөгжлийн Цогц Бодлого (ҮХЦБ: 2008-2021)-ыг боловсруулан. Уг цогц бодлогод “Экспортын баримжаатай жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг гаалийн тарифын бодлогоор дэмжих”; “Импорт орлох зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг гаалийн тарифын бодлогоор дэмжих”; “Өндөр технологийн болон оюуны шингэц бүхий бага оврын техник,

тоног төхөөрөмжийн импортыг гаалийн тарифын бодлогоор дэмжих” гэх зэргээр тусгасан нь гаалийн тарифын зохицуулах үүргийг хангахад чухал баримт бичиг болсон.

Энэхүү цогц бодлогыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2009 онд “Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр: 2009-2016”-ийг хавсралтаар баталсан. Хөтөлбөрт үйлдвэрлэлийн зориулалтаар импортолж байгаа тоног төхөөрөмж болон Монгол Улсад орлуулах боломжгүй түүхий эд, тухайн түүхий эдээр хийсэн эцсийн бүтээгдэхүүний гаалийн татварыг тодорхой хугацааны дараа буюу уг тоног төхөөрөмжийг ашиглаж байгаа үйлдвэрийн үйл ажиллагаа жигдэрсэн үед авах боломж; цөм технологийн үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх, татварыг дараа тооцох эрх зүйн үндсийг бүрдүүлэх зэрэг асуудлыг тусгасан.

2010 оны 7 дугаар сард Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг Улсын Их Хурлаар шинээр баталсан. Уг үзэл баримтлалд “...Гадаад худалдааны алдагдлыг багасгаж, тарифын болон тарифын бус арга хэрэгслийг дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зохистой хэрэглэнэ...” гэж заасан.

2. Гаалийн тарифын зохицуулах үүргийг нэмэгдүүлэх зорилгоор хууль эрхзүйн актуудад өөрчлөлт оруулсан.

Дээрх бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлэх зорилгоор 2008 онд Гаалийн тариф, гаалийн татварын

тухай хуулийг шинэчлэн баталсан ба 2012-2014 онд 8 удаа⁵ нэмэлт, өөрчлөлт оруулсан. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь дотоодын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжихэд гаалийн тарифын зохицуулах үүргийг хэрэгжүүлэхэд чиглэж байсан.

Тухайлбал, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт орж, дараах бараа **гаалийн татвараас чөлөөлөгдөхөөр болсон**. Үүнд:

- ✓ 2012 оны 5 дугаар сарын 22-ны өөрчлөлтөөр инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодис.
- ✓ 2014 оны 7 дугаар сарын 01-ний өөрчлөлт:
 - о гэрээлэгч болон туслан гүйцэтгэгч нь газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан хайгуулын нийт хугацаанд болон ашиглалтын эхний таван жилийн хугацаанд импортолсон тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоноглол, түүхий эд, материал, химийн болон тэсрэх бодис, сэлбэг хэрэгсэл;
 - о газрын тос болон уламжлалт бус газрын

тостой холбогдсон тайлан материал, дээж болон газрын тос;

- о нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй, ижил төрлийн хоёроос илүүгүй бараа бүхий хувь хүний нэр дээр илгээсэн улс хоорондын шуудангийн илгээмж.

Түүнчлэн УИХ-ын 1999 оны “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” 27 дугаар тогтоолын хавсралтад энэ хугацаанд дараах нэмэлт, өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- ✓ 2008 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 45 дугаар тогтоолоор Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний гаалийн тариф 0-5%; Эрдэс түлш, битумын эрдэс, эрдэс лав, цахилгаан эрчим хүчний гаалийн тариф 5% байхаар өөрчлөлт оруулж мөрдсөн.
- ✓ 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 26 дугаар тогтоолоор Шувууны өндөг -15%; Цагаан идээ, зөгийн бал ба бусад газар заагдаагүй мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн - 5%; Төмс -15% байхаар гаалийн тарифын хувь, хэмжээнд өөрчлөлт оруулж мөрдсөн.
- ✓ 2011 оны 5 дугаар сарын 16-ны 19 дүгээр тогтоолоор

5 2012 онд 4, 2013 онд 1, 2014 онд 3

Сонгино, Байцаа, Шар луван, Шар манжинд 15%, БТКУС-ийн ангилалын 11.01, 11,02 дахь зүйлийн гурилыг Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор импортолсон бол 7 дугаар сарын 01-нээс 4 сарын 01 хүртэл 15% ба 4 сарын 01-нээс 7 дугаар сарын 01 хүртэл 5%, харин бусад боомтоор импортолсон бол 15% байхаар гаалийн тарифын хувь, хэмжээнд өөрчлөлт оруулж мөрдсөн.

- ✓ 2012 оны 9 дүгээр сарын 11-ний 27 дугаар тогтоолд заасан хязгаарт багтаан газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь, хэмжээг салбарын онцлогийг харгалзан тогтоох эрхийг Засгийн газарт олгосон.
- ✓ 2013 оны 5 дугаар сарын 24-ний 40 дүгээр тогтоолоор Бухын үр (HS 0511.10.00), Үржлийн мал, амьтны үр (бухын үр орохгүй), ийлдэс (HS 0511.99.10), Малын хөврөл үр (HS 0511.99.50) гаалийн тарифыг “тэг” болгосон.
- ✓ 2013 оны 6 дугаар сарын 7-ны 44 дүгээр тогтоолоор 1 жилийн насжилттай нийтийн тээврийн автобус (HS 8702.10.21 & 8702.90.31), троллейбус

(HS 8702.90.13)-ны гаалийн тарифыг “тэг” болгосон.

Хэдийгээр энэ үе шатанд гаалийн тарифын зохицуулалтын үүргийг нэмэгдүүлэх зорилготой томоохон бодлогын бичиг баримтууд гарч, гаалийн тарифын тухай хуулийг шинэчлэн найруулсан ч хэрэгжилт төдийлөн сайн байж чадаагүй юм.

2011 онд 17.5 хувиар өсч байсан Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хурдац тогтмол саарч⁶ 2016 оны эхний 3 сарын байдлаар 3.1 хувь болсон. Энэхүү бууралтад экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ унасан, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ огцом буурсан зэрэг гадаад хүчин зүйлс ихээхэн нөлөөлсөн.

ДНБ-д боловсруулах аж үйлдвэрийн салбарын нэмүү өртгийн эзлэх хувийн жин 5-6 хувь⁷ байгаа нь дэлхийн дундаж болон бага орлоготой орнуудын дунджаас даруй 3-4 дахин доогуур байна.

Монгол Улс эдийн засгийн олон тулгуурт, бие даасан, тогтвортой хөгжилд шилжихийн тулд экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлийг төрөөс онцгойлон анхаарч нэгдсэн бодлого зохицуулалт, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлага байсан. Энэ хүрээнд тухайн үеийн Аж үйлдвэрийн яамнаас “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль”-ийн төслийг боловсруулан 2014 онд УИХ-д оруулж, хэд хэдэн удаа нээлттэй хэлэлцүүлэг хийсэн

6 2012 онд 12.5%, 2013 онд 11.7 %

7 Монгол Улсад төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед үйлдвэрлэл хөгжин боловсруулалтын нэмүү өртөг ДНБ-ий 1/3-г эзэлж байсан.

үеэс үндэсний үйлдвэрийг төрийн бодлогоор дэмжих үйл явц хүчтэй өрнөж эхэлсэн гэж хэлж болно.

Үйлдвэржилтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, боловсруулах үйлдвэрийн чадавхийг дээшлүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэн дотоодын зах зээлийн хэрэгцээг хангах, улмаар жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин ажлын байр бий болгох зорилгоор ХАА, газар тариалан, хөнгөн үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор шат дараатай ажлуудыг төлөвлөсөн.

ДХБ нь гаалийн тарифыг худалдаанд хамгийн бага хохирол учруулах ил тод механизм гэж үзэхийн зэрэгцээ дотоодын үйлдвэрлэлийг гаалийн тарифаар хамгаалах явдлыг гол зорилгоо болгодог. Монгол Улс импортын барааны гаалийн тарифын ижилтгэсэн хувь, хэмжээг тогтвортой байдлаар мөрдөж ирсэн бөгөөд гаалийн тарифын зохицуулах үүргийг нэмэгдүүлэх зорилгоор ялгавартай тарифыг хэрэглэх саналыг холбогдох яам, агентлагуудаас оруулж эхэлсэн.

Монгол Улс ДХБ-ын Худалдааны бодлогыг хянан хэлэлцэх зөвлөл (ХБХХЗ)-ийн 2014 оны 9 дүгээр сарын 24-26-ны өдрүүдийн хуралдаанаар Монгол Улсын худалдааны бодлогын тухай илтгэлийг 2 дахь удаагаа хэлэлцүүлж, 2005-2014 онд Монгол Улсын гадаад худалдааны бодлогод гарсан өөрчлөлтүүдийг ДХБ-ын гишүүн орнуудын анхааралд сонордуулахын зэрэгцээ худалдаа,

эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдал, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлого, зорилтыг танилцуулсан билээ.

Үндэсний үйлдвэрлэлийг гаалийн тарифын бодлогоор дэмжсэн үе буюу 2015 оноос хойш.

УИХ-ын 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн чуулганаар “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль”-ийг баталсан⁸ нь үндэсний үйлдвэрлэлийг тарифын бодлогоор дэмжих үйл явц шинэ шатанд гарах боломжийг бүрдүүлсэн.

Хуулийн зорилт нь өрсөлдөх чадвартай, үнэ цэнэ шингэсэн, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний экспортын чиг баримжаатай, импортыг орлох үйлдвэрлэлийг төрөөс дэмжин хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдсэн⁹.

Энэ хуультай холбогдон дагалдах бусад хуулиудад чухал өөрчлөлтүүд орсон. Тухайлбал, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд 2015 оны 12 дугаар сард өөрчлөлт орж, сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэгийг **гаалийн татвараас чөлөөлөхөөр болсон.**

Монгол Улс Япон улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЭЗТХ) байгуулснаар Япон улсаас гарал үүсэлтэй бараанд бусад ийм хэлэлцээргүй орноос давуу нөхцөл олгож “хөнгөлөлттэй тариф”-ыг хэрэглэх ёстой. Иймд “Гаалийн тариф,

8 2019 оны 11 сарын 13-нд уг хуулийг тодрхойгүй үндэслэлээр хүчингүй болгосон байна.

9 Үйлдвэрлэлийг дэмжих тухай Монгол Улсын хууль, 2015

гаалийн татварын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулж¹⁰ энэ асуудлыг шийдвэрлэсэн.

Түүнчлэн “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолд оруулсан өөрчлөлт нь үндэсний үйлдвэрлэлийг гаалийн тарифын бодлогоор дэмжих, хамгаалах нэг гол зохицуулалт болжээ.

Энэхүү өөрчлөлтийн¹¹ хүрээнд зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тухайн салбарын бүтээгдэхүүний онцлогийг харгалзан тогтоох эрхийг Монгол Улсын Засгийн газарт олгосон нь үндэсний үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан тарифын бодлогоор дэмжихэд томоохон түлхэц болсон гэж үзэж болох юм.

Дэлхийн улс орнууд өөрийн орны импортын тарифын бодлогыг тодорхойлохдоо үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, хүн амын хүнсний хэрэгцээг хангах, стратегийн барааны гадаад худалдааны эргэлтэд хяналт тавих үйл ажиллагаатай уялдуулдаг билээ.

Монгол Улс ч сүүлийн жилүүдэд үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах үйлдвэрлэлийг урамшуулах зорилгоор импортын гаалийн тарифын хувь, хэмжээг тус улсын ДХБ-тай тохирсон

дээд хэмжээнд хүртэл нэмэгдүүлэхэд илүү анхаарлаа хандуулж байгаа юм.

2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн УИХ-ын 74 дүгээр тогтоолоор Засгийн газар хүнсний зарим бүтээгдэхүүн, ноос, ноолууран болон оёмол бүтээгдэхүүн зэрэг БТКУС-ийн 30 гаруй бүлгийн¹² барааны одоо мөрдөж байгаа импортын гаалийн тарифын 5 хувийн түвшинг ДХБ-тай тохирсон дээд хэмжээнд хүргэх эрхтэй болсон.

Монгол Улсын Засгийн газар энэ эрхийнхээ дагуу **“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтад хэд хэдэн нэмэлт өөрчлөлт оруулсан.**

Үүнд:

- ✓ 2015 оны 8 дугаар сард БТКУС-ийн 02, 04, 16, 25, 87 дугаар бүлгийн мах, дайвар мах, зөгийн бал, нөөшилсөн бүтээгдэхүүн, цемент, троллейбусны гаалийн тарифын хувь, хэмжээг нэмэгдүүлсэн¹³. Тарифын энэхүү бодлого нь эдгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн. Тухайлбал, цементийн импорт 46 хувь буюу 82 тэрбум төгрөгөөр буурч, экспорт 1.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, үхрийн

10 “Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль”-ийн 4.2.Импортын барааны гаалийн тарифыг ердийн, нэн тааламжтай, хөнгөлөлттэй тариф гэж ангилах бөгөөд ердийн тариф нэн тааламжтай тарифаас хоёр дахин их байна. Хөнгөлөлттэй тарифыг олон улсын гэрээгээр тогтооно” гэж /Энэ хэсгийг 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.

11 УИХ-ын 74 дүгээр тогтоолыг 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар баталсан.

12 БТКУС 02, 04, 07, 08, 16, 19-21, 22 (22.01, 22.02, 22.09), 25, 26, 35, 39, 40- 44, 48, 49, 51, 56, 57, 61-64, 68-70, 87, 94

13 2015.8. 17-ний өдрийн 332 дугаар тогтоол

махны импорт 40 хүртэл хувь буюу 84 сая төгрөгөөр буурч, экспорт 65 хувь буюу 2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, зөгийн балны импорт 16 хувь буюу 460 сая төгрөгөөр буурч, экспорт 10 дахин буюу 41 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Зөвхөн цемент, үхрийн мах, зөгийн балд дүн шинжилгээ хийхэд 82.5 тэрбум төгрөгийн гадагшлах урсгалыг зогсоож, 3.2 тэрбум төгрөгийг эдийн засагт оруулсан гэсэн тооцоо байна.

- ✓ 2016 оны 2 дугаар сард импортын архи, дарсны гаалийн тарифыг нэмэгдүүлсэн. **Тухайлбал, энэ** оны 3 дугаар сарын 1-нээс цагаан архинд 40 хувь, дарсанд 20 хувийн гаалийн татвар ногдуулж эхэлсэн¹⁴. Үүний зэрэгцээ Монгол Улс ДХБ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон улс хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Онцгой албан татварын тухай хуульд 2016 оны 2 дугаар сард нэмэлт, өөрчлөлт оруулж импортын

болон дотоодын үйлдвэрийн архи, дарсанд ногдуулж байсан ялгавартай татварыг ижилтгэсэн¹⁵.

- ✓ 2016 оны 3 дугаар сард БТКУС-ийн 14 бүлгийн (04, 07, 21, 39, 44, 49, 51, 56, 61, 63, 64, 68, 69, 94) 100 гаруй барааны гаалийн тарифын хувь, хэмжээг нэмэгдүүлсэн ба 5 дугаар сарын 1-ээс дагаж мөрдсөн¹⁶.
- ✓ 2017 оны 4 дүгээр сард импортын тамхины гаалийн тарифын хувь, хэмжээг нэмэгдүүлэхээр болсон ба 5 дугаар сарын 1-ээс дагаж мөрдсөн¹⁷.

Импортын зарим бараанд ногдуулах гаалийн татварын хувь, хэмжээг нэмэгдүүлснээр дотоодын үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүнтэй ижил нэр төрлийн бүтээгдэхүүний импортын бараа буурах, дотоодын үйлдвэрлэл нэмэгдэх, өрсөлдөх чадварт эергээр нөлөөлөх, экспорт нэмэгдэх, ажлын байр нэмэгдэж, ард иргэдийн орлого өсөхөөс гадна шинэ ноу-хау нэвтрэх өргөн боломж бий болно гэж үзэж байгаа ч тодорхой судалгаа чухал байгаа юм.

14 2016.02. 5-ны өдрийн 17 дугаар тогтоол

15 Онцгой албан татварын тухай Монгол Улсын хууль, 2006

16 2016.3.28-ны өдрийн 185 дугаар тогтоол

17 2017.4.14-ний өдрийн 27 дугаар тогтоол

II. Гаалийн тарифын шинжилгээ

Бид өмнөх судалгааны ажлын хүрээнд **“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан суурь тарифын хувь, хэмжээг өөрчлөхөд эдийн засагт үзүүлэх нөлөөллийг GTAP мэдээллийн сангийн 8.1 хувилбар болон GTAP загвар ашиглан дараах 2 хувилбараар тооцоолсон билээ. Үүнд:**

А хувилбар: 2015-2016 онуудад зарим барааны импортын гаалийн тарифыг ДХБ-тай тохирсон тарифын дээд хэмжээнд хүргэж шинэчилснээр гарсан нөлөөлөл;

Б хувилбар: Нийт барааны импортын гаалийн тарифыг ДХБ-тай тохирсон тарифын дээд хэмжээнд хүргэсэн тохиолдолд гарах нөлөөлөл.

Энэхүү шинжилгээг хийхдээ БТКУС-ийн 6 орны түвшинд гаргасан Монгол Улсын гаалийн тарифын жагсаалт дах бараа бүтээгдэхүүнийг олон улсын аргачлалын¹⁸ дагуу GTAP-ын салбарын ангилалд хөрвүүлсэн болно.

Симуляцын зарим үр дүнгээс¹⁹ харахад гаалийн тарифын шинчлэлийн бодлого нь Монгол Улсын ДНБ-ний хэмжээнд эерэг нөлөө үзүүлэхээр байна. ДНБ-ний бодит өсөлт А хувилбарт 0.22%-иар, Б хувилбарт 2.09%-иар тус тус суурь үеийнхээс нэмэгдэх боломжтой.

Харин хөрөнгө оруулалтын хэмжээ суурь үеийнхээс аль ч хувилбарт буурах үзүүлэлтэй гарсан ба тус бууралтын хэмжээ А хувилбарт 0.04%, Б хувилбарт 8.36%-тай байв.

Импортын гаалийн тарифыг нэмэгдүүлэх нь тухайн орны үндэсний валютын бодит ханш өсөхтэй ижил нөлөө үзүүлдэг тул эдгээр тарифын шинэчлэлийн бодлогын дүнд Монголын бараа бүтээгдэхүүн дэлхийн зах зээл дээр харьцангуй үнэтэй болж, нийт экспортын дүн А хувилбарт 0.1%-иар, Б хувилбарт 0.06%-иар тус тус багасахаар байсан. Үүний зэрэгцээ, импортын тарифын хувь хэмжээг нэмэгдүүлснээр импорт багасаж, дотоодын үйлдвэрлэл өснө гэсэн хүлээлтийн дагуу нийт импортын хэмжээ суурь үеийнхээс А хувилбарт 0.2%-иар, Б хувилбарт 6.5%-иар тус тус буурах дүн гарсан.

Монгол Улсын худалдааны нөхцөл А хувилбарт суурь үеийнхээсээ 0.026%-иар сайжирч, Б хувилбарт 0.59%-иар муудах дүн гарсан хэдий ч, гадаад худалдааны тэнцэл 2 хувилбарын аль алинд нь сайжрахаар байв.

Салбарын шинжилгээнээс харахад, хэдийгээр дотоодын зах зээлээс түүхий эдээ бүрэн хангах боломж сайтай сүү, сүүн бүтээгдэхүүний хувьд дотоодын хэрэгцээгээ хангах хувь бага хэмжээгээр буюу 2 хувилбар дээр 1.4%, 3.4% тус тус нэмэгдэхээр байгаа нь

18 World integrated solution (WITS)-ийн Product Concordance HS combined to GTAP

19 Шинжилгээний дэлгэрэнгүйг дараах холбоосоор үзнэ үү <https://www.gtap.agecon.purdue.edu/resources/download/8387.pdf>

хангалтгүй үзүүлэлт. Энэ нь Монгол Улсын аж үйлдвэрлэлийн бүтэц, салбар хоорондын уялдаа холбоо өнөөгийн байдлаар дотоодын түүхий эдээ бүрэн ашиглан сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр өөрийн хэрэгцээгээ бүрэн хангах төвшинд хүртэл хөгжиж чадаагүй байгааг харуулж буй нэг хүчин зүйл юм. Бусад хүнсний бүтээгдэхүүн, хүнсний ногоо, улаан буудай, үр тариа гэх зэрэг салбаруудын хувьд ч мөн ижил дүр төрх ажиглагдаж байна.

Импортын гаалийн тариф тогтоосноор тухайн салбарын дотоодын үйлдвэрлэл нэмэгдэхийн хэрээр түүнд шаардагдах түүхий эд, материал, ажиллах хүч зэрэг үйлдвэрлэлийн хэрэгцээт нөөц, холбогдох үйлчилгээний эрэлт нэмэгдэж, салбаруудын өрсөлдөөн ихсэх ба энэ нь тухайн орны аж үйлдвэрийн салбарын бүтцийн өөрчлөлтөд мөн нөлөөлдөг.

Энэхүү өрсөлдөөний улмаас импортлогч орны цалин, түрээсийн хэмжээ дэлхийн бусад оронтой харьцуулахад харьцангуй өндөр болох тул үндэсний валютын ханшийн бодит өсөлттэй ижил үр дагаварт хүргэнэ. Бидний шинжилгээний А хувилбарын хувьд, Монгол Улс сүү, сүүн бүтээгдэхүүний импортын тарифыг 5%-иас 12% болгож 7%-иар нэмэгдүүлэхэд сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ 0.59%, дотоодын үйлдвэрлэл 2.98%-иар тус тус нэмэгдэж, импортоор оруулж ирсэн сүү, сүүн бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнэ 6.91% өндөр болох юм.

Өмнө дурьдсанчилан, А хувилбарын хувьд импортын

тарифын хувь хэмжээ нэмэгдсэн бүх салбаруудын үйлдвэрлэл өсөхийн хэрээр тэдгээрт шаардагдах үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн эрэлт нэмэгдэж, бусад салбарынх буурахаар байна. Жишээлбэл, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардагдах ажиллах хүчний хэрэгцээ 3.4%, газар 1.8%, капитал 3.4%, байгалийн нөөц 0.005%-иар тус тус нэмэгдэх дүн гарсан. Үүний улмаас, газар болон ажиллах хүчний зах зээлийн үнэ өсөж, газрын үнийн өсөлт 0.5%, ажиллах хүчний үнийн өсөлт 0.01%-тай байлаа.

Хүнсний ногоо, жимс, самраас бусад тарифын шинэчлэл хийгдсэн бүх салбаруудын хувьд мөн ижил үр дүн харагдсан. Харин хүнсний ногоо, жимс, самрын хувьд, А хувилбарт 0.027 сая ам. доллартай тэнцэх нөөц ашиглалтын ашигтай гарч, харин үйлдвэрлэлийн хэмжээ 0.43%-иар буурах дүн гарсан.

Импортын гаалийн тарифын шинэчлэлийн бодлогын Б хувилбарын хувьд ерөнхийдөө ижил үр дүн гарч байгаа боловч түүний цар хүрээ А хувилбараас нилээд их байна. Жишээлбэл, бүх барааны импортын гаалийн тарифыг ДХБ-тай тохирсон хувь хэмжээнд хүртэл нэмэгдүүлэх тохиолдолд сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ 2.57% буурсны үр дүнд эрэлт өсч, үйлдвэрлэлтийн хэмжээ 11.5% нэмэгдэх нь. Үүнтэй холбоотойгоор сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардагдах ажиллах хүчний эрэлт 13.4%, капиталын хэрэгцээ 13.3%-иар тус тус өсөхөөр байлаа. Мөн үйлдвэрлэлийн хэрэгцээт газар болон байгалийн баялгийн эрэлт 6.8% болон

0.01%-иар тус тус нэмэгдэх төлөвтэй байв.

Хүлээлт ёсоор сүү, сүүн бүтээгдэхүүний импортын хэмжээ Б хувилбарт 28.7% буурах дүн гарав. Харин, үндэсний валютын ханшний бодит өсөлтийн нөлөөллөөс үл хамааран сүү сүүн бүтээгдэхүүний экспортын хэмжээ Б хувилбарт 18.7%-

иар нэмэгдэж байгаа нь А хувилбараас эсрэг үр дүн болов. Энэ нь сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ буюу экспортын үнэ 2.5%-иар буурч байгаатай холбоотой. Ингэснээр Монголын сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээлд харьцангуй хямд болж, өрсөлдөх чадвар нь сайжирна.

III. Дүгнэлт

Монгол Улсын эдийн засагт гадаад худалдаа чухал нөлөө үзүүлдэг тул гадаад худалдааны бодлого, түүний эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нарийвчлан судалж, ойлгох нь ихээхэн ач холбогдолтой юм.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж эхэлснээс хойших үеийн импортын гаалийн тарифын бодлого зохицуулалтыг нэгд, шилжилтийн үе буюу гадаад худалдаанд импортын гаалийн тарифыг нэвтрүүлж эхэлсэн үе (1991-1996), хоёрт, олон талт зохицуулалтын үе буюу гадаад худалдааны бодлогыг олон талт зохицуулалтын дүрэм журамд нийцүүлэх үе (1997-2007), гуравт, гаалийн тарифын зохицуулах үүргийг нэмэгдүүлсэн үе (2008-2014), дөрөвт, үндэсний үйлдвэрлэлийг гаалийн тарифын бодлогоор дэмжиж эхэлсэн үе (2015 оноос хойш) гэсэн үндсэн 4 үе шатанд хувааж үзэж болохоор байна.

Өнөөгийн Монгол Улсын гаалийн тарифын үндэсний зохицуулалт бий болох үндэс суурь 1991 онд тавигдсан ба Монгол Улс 1997 онд ДХБ-д элссэнээр үндэсний зохицуулалтыг олон талт худалдааны зохицуулалтад нийцүүлэх шаардлагатай болсон.

Шилжилтийн болон олон талт зохицуулалтын үед буюу 1991-2007 онд гаалийн тарифын улсын төсвийн орлого бүрдүүлэх үүрэг өндөр байсан бол 2008 оноос гаалийн тарифыг дотоодын импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг урамшуулахад чиглэгдэж эхэлсэн гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл 2008 оноос төрийн бодлогын баримт бичигт гаалийн тарифын зохицуулах үүргийг нэмэгдүүлэх замаар үндэсний эдийн засгийг хөгжүүлэх асуудлууд тусгалаа олж, холбогдох хууль эрхзүйн актуудад өөрчлөлт оруулсан байдаг.

“Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль”-ийг 2015 онд баталж, үндэсний үйлдвэрлэлийг тарифын бодлогоор дэмжих боломжийг нэмэгдүүлсэн ч 2019 оны 11 дүгээр сард хүчингүй болгожээ. Цаашид дотоодын үйлдвэрлэлийг тарифын бодлогоор оновчтой хамгаалах хууль эрхзүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай юм.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын мөрдөж буй импортын гаалийн тарифын хувь хэмжээ тус орны ДХБ-тай тохирсон дээд хэмжээнээс харьцангуй бага байгаа билээ. Үндэсний үйлдвэрлэлийг

дэмжих бодлогын хүрээнд Монгол Улсын засгийн газраас дотоодод үйлдвэрлэгддэг зарим барааны импортын гаалийн тарифын хувь хэмжээг 2015-2016 онуудад нэмэгдүүлсэн (А хувилбар) ба цаашид бүх барааны импортын гаалийн тарифын хувь хэмжээг ДХБ-тай тохирсон дээд хэмжээнд хүртэл өсгөх (Б хувилбар) боломжтой.

Тарифын шинэчлэлийн бодлогын Монгол Улсын эдийн засагт үзүүлэх үр нөлөөг ГТАР мэдээллийн сангийн 8.1 хувилбар болон ерөнхий тэнцвэрийн ГТАР загвар ашиглан хийсэн шинжилгээний дүнгээс харахад, хэдийгээр дээрх 2 хувилбарын аль алинд Монгол Улсын ДНБ өсөхөөр байгаа боловч нийгмийн нийт баялагын хувьд аль ч хувилбарт

алдагдал хүлээх үр дүн гарч байгааг бодлого боловсруулагчид анхаарах шаардлагатай юм.

Нөгөө талаас импортын тарифын шинэчлэлийн бодлого нь Монгол Улсын аж үйлдвэр болон худалдааны бүтцэд тодорхой нөлөө үзүүлэхээр байна. Хэрэв Монгол Улс импортын гаалийн тарифын хувь хэмжээг ДХБ-тай тохирсон дээд хэмжээнд хүртэл нэмэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын боловсруулах үйлдвэрлэлийн голлох салбарууд болох малын гаралтай түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх мах, сүү, ноос, ноолуур, арьс ширний салбарын үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэхийн зэрэгцээ экспортын хэмжээ ч мөн өсөхөөр байна.

Ашигласан материал

1. “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2012 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн УИХ-ын 27 дугаар тогтоол. <https://www.legalinfo.mn/additional/details/2716?lawid=6093>
2. “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн УИХ-ын 74 дүгээр тогтоол <https://www.legalinfo.mn/additional/details/2718?lawid=6093>
3. “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн УИХ-ын 27 дугаар тогтоол. <https://www.legalinfo.mn/law/details/6093>
4. “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн УИХ-ын 17 дугаар тогтоол. <https://www.legalinfo.mn/additional/details/2384?lawid=6093>

5. “Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай” 2015 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын 332 дугаар тогтоол <https://www.legalinfo.mn/law/details/11288>
6. “Импортын зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай” 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын 185 дугаар тогтоол. <https://www.legalinfo.mn/law/details/11845>
7. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн УИХ-ын 27 дугаар тогтоол <https://www.legalinfo.mn/additional/details/3061?lawid=6093>
8. Enkhbayar SH., Otgonsaikhan N. Impacts of Import Tariff Reforms on Mongolia’s Economy: CGE Analysis with the GTAP 8.1 Data Base. The Northeast Asian Economic Review Vol.5, No.1, March 2017 <https://www.gtap.agecon.purdue.edu/resources/download/8387.pdf>
9. World integrated solution (WITS)-ийн Product Concordance HS combined to GTAP. https://wits.worldbank.org/product_concordance.html
10. World Tariff Profiles 2019. https://www.wto.org/english/res_e/booksp_e/tariff_profiles19_e.pdf
11. Гаалийн тариф, гаалийн татварын тухай Монгол улсын хууль (2008). <https://www.legalinfo.mn/law/details/208?lawid=208>
12. Гаалийн тарифын тухай Монгол улсын хууль (1996)
13. Н.Отгонсайхан. Пополнение бюджета Монголии на основе тарифного регулирования внешней торговли, кандидатская диссертация. Байкальский государственный университет экономики и права, Россия. –с.185
14. Онцгой албан татварын тухай Монгол улсын хууль (2006). <https://www.legalinfo.mn/law/details/434?lawid=434>
15. Үйлдвэрлэлийг дэмжих тухай Монгол улсын хууль (2015).
16. Ш.Цогтоо. Гаалийн эрхзүй. Сурах бичиг. – Улаанбаатар. Хөх судар, 2003. – х.506

Customs tariff reforms in Mongolia

Otgonsaikhan, Nyamdaa*

*Ph.D. in economics. Professor, National University of Commerce and Business,
Ulaanbaatar, Mongolia, otgonsaikhan@nucb.edu.mn*

Enkhbayar, Shagdar

*Ph.D. in economics. Senior Research Fellow, Research Division,
Economic Research Institute for Northeast Asia, Ulaanbaatar, Mongolia
enkhee@erina.or.jp*

Abstract. *Mongolia has been pursuing a free trade policy since the transition to a market economy, and today, with a sharp increase in imports and a boom in raw materials exports, domestic production has fallen, and the country became overly dependent on mining products. Therefore, there is an urgent need to review the methods for implementing foreign trade policy, to study their optimal use and update them effectively. This study examines how Mongolia's import tariff regulations have been reforming since the transition to a market economy, and discusses some potential impacts of the import tariff reform on the Mongolian economy. .*

Key words. *Foreign trade policy; import customs tariff policy and regulation; most-favoured-nation (MFN) tariff; bound tariff; tariff analysis.*

The day of submission: 2020.7.02

Completion of review: 2020.11.5

Final decision for acceptance: 2020.11.6

* Corresponding author